



“МИАТ” ТӨХК-Д

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.29 № 0314424.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102007 дугаартай “Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1, 3 дугаар багцад оролцсон “Грандавто ланд” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Грандавто ланд” ХХК-ийн гомдолд тус компанийн ирүүлсэн тендерээс регистрийн дугаар зөрүүтэй, компанийн нэр бичигдээгүй, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс цахим лавлагаа ирүүлээгүй нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2-т заасан шаардлагыг хангахгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэртэй санал нийлэхгүй, мөн тус тендер шалгаруулалтын 1, 3 дугаар багцад шалгарсан “Кей жи платформ” ХХК нь техникийн тодорхойлолтыг маягтын дагуу бэлтгээгүй, ижил төстэй ажлын төсөвт өртгийн хэмжээ 50 хувиас бага, ижил төстэй ажлын гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ижил төстэй ажилд тооцуулахаар ирүүлсэн гэрээ нь ижил төстэй ажлаас өөр хамааралгүй гэрээ ирүүлсэн, 2024 оны гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн, мөн нэг удаагийн хуванцар саван дахь хар тугалганы хэмжээг илэрхийлэх шинжилгээний бичиг нь эрүүл ахуйн стандартыг зөрчсөн байхад гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5 дахь хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 59.3, 59.4-т заасан шаардлагыг хангахгүй, эсхүл шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаана” гэж заасан бөгөөд “Кей жи платформ” ХХК-аас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А2023-159 тоот албан бичгээр гаргасан гомдлын хүрээнд тус яам “Гранд автоланд” ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад заасан этгээдийн лавлагаа ирүүлэх шаардлагыг хангах эсэх асуудлыг хянан үзэж, хариуг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 03/2745 тоот албан бичгээр хүргүүлсэн байх тул албан бичигт

9766007757

дурдсан “Грандавто ланд” ХХК-ийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэртэй холбоотой асуудлыг хянан үзэхгүй болно.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон ирүүлсэн “Кей жи платформ” ХХК-ийн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.3-т “Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.” гэж заасны дагуу оролцогчийн санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагад нийцэж байгаа талаар захиалагчийн өгөгдлийн хүснэгтэд заасан нотлох баримтыг тендерт ирүүлэхээр заадаг тул “Кей жи платформ” ХХК нь техникийн тодорхойлолтыг маягтын дагуу ирүүлээгүй талаарх гомдол үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д “ Оролцогчийн туршлагыг харуулах өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл”, “Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ/” гэж заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт оролцогчийн ирүүлсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний үнийн дүн төсөвт өртгийн 50 хувиас их байх шаардлагыг тусгаагүй байх тул “Кей жи платформ” ХХК-ийн ирүүлсэн ижил төстэй ажлын төсөвт өртгийн хэмжээ 50 хувиас бага байгаа нь шаардлага хангахгүй талаарх гомдол үндэслэлгүй байна.

“Кей жи платформ” ХХК-ийн тендерт ирүүлсэн ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэлд “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар”-тай 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан “ЧДХААА ДТХ Б21/20” дугаартай “Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж (тусгай зориулалтын техник, хэрэгсэл) нийлүүлэх гэрээ”, “МИАТ” ТӨХК-тай 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “23/129”, “23/130” дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”, 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “23/128” дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”, 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан “23/229” дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”, Монгол Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгтэй 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “ХХГ-НТШ/23/124” дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”, “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар”-тай 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан “ЧДХААА ДТХ Б21/20” дугаартай “Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж (тусгай зориулалтын техник, хэрэгсэл) нийлүүлэх гэрээ”, гэрээ дүгнэсэн актыг тус тус ирүүлсэн байгаа нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-д “Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан байх ба “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ эсвэл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ. /Хуванцар лацнаас бусад бараа бүтээгдэхүүний хувьд/” гэж заасан байна.


“Кей жи платформ” ХХК-ийн тендэрт 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “БД № 2372” дугаартай нэг удаагийн хуванцар аяганы “Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгийн хуудас”-ийг ирүүлсэн байх бөгөөд шинжилгээний үр дүнгийн “Хар тугалга мг/кг ихгүй” хэмжих нэгжийн үзүүлэлт “ <0.015” гэж тусгагдсан байгаа нь эрүүл ахуйн стандартыг зөрчих эсэхийг судалж, тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцэх эсэхийг нягтлан үзэх нь зүйтэй байна.

Журмын 5.9-д “Сангийн яам гомдол хянан шийдвэрлэхэд хуулийн 59.10-т зааснаар хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй асуудлаар захиалагчийг хуулийн 48.2.3-т заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавихыг даалгасан бол захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж, оролцогчид мэдэгдэнэ” гэж заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Грандавто ланд” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

A square stamp containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to be 'Ж. ГАНБАТ'. The stamp is slightly faded and has a dotted border.

Ж.ГАНБАТ